



## УДИРДАМЖ

2024 оны 05 дугаар сарын 14

Арвайхээр

"Цахим шилжилтийг эрчимжүүлэх" зорилтот жил болон "Нээлттэй засгийн түншлэлийн долоо хоног-2024" арга хэмжээний хүрээнд зохион байгуулах идеатон тэмцээний тухай

**Зохион байгуулагч:** Өвөрхангай аймгийн Засаг даргын Тамгын газар

**Зорилго:** "Цахим шилжилтийг эрчимжүүлэх" зорилтот жилийн ажлын хүрээнд иргэд, олон нийтийн цахим ур чадварыг дээшлүүлэхэд чиглэсэн цаашид хэрэгжүүлэх боломжтой идеатон<sup>1</sup> төслийг шалгаруулж, хөгжүүлэх, иргэн, иргэний нийгмийн байгууллага, хувийн хэвшил болон орон нутгийн удирдлагаас хамтран ажиллах боломжийг нэмэгдүүлэхэд оршино.

**Сэдэв:** Дараах сэдвийн хүрээнээс сонгох

- Иргэд, олон нийтийн цахим ур чадварыг дээшлүүлэх нь
- Мэдээлэл, харилцаа холбооны технологи, тоног төхөөрөмжийн ашиглалтыг сайжруулах нь
- Цахим орчинд үнэн болон худал өгөгдөл, мэдээллийг ялгах талаарх мэдлэг ойлголтыг дээшлүүлэх нь

**Баг бүрдүүлэх насны ангилал:** 15-20 нас, 21-27 нас, 28-34 нас

**Багийн бүрэлдэхүүн:** Баг тус бүр 3-5 хүний бүрэлдэхүүнтэй оролцоно.

**Хугацаа:** 2024 оны 05 дугаар сарын 20-24-ний өдрүүдэд төслийн танилцуулга хүлээн авч, 2024 оны 05 дугаар сарын 29-30-ны өдрүүдэд шалгарсан багууд төслөө танилцуулна.

**Үе шат:**

1 дүгээр шат-Төсөл хүлээн авах, оролцох багийг шалгаруулах

-Сэдвийн хүрээнд асуудал дэвшүүлж, шийдэл тодорхойлох

-Дээрхийг 5 минутад багтаан танилцуулга видео бэлтгэн ирүүлэх

Жич: 05 дугаар сарын 20-ны өдрөөс 24-ний өдрийн хооронд төслийн танилцуулга видеог [info@ov.gov.mn](mailto:info@ov.gov.mn) цахим хаягаар хүлээн авч, 1 дүгээр шатанд шалгарсан багуудад 05 дугаар сарын 27-ны өдөр хариу мэдэгдэнэ.

2 дугаар шат-Төслийн танилцуулга хийх, шилдэг баг (идеатон)-г шалгаруулах

-Нэгдүгээр шатанд шалгарсан багууд төслийн танилцуулгыг Microsoft Powerpoint хэлбэрээр бэлтгэж, 20 минутад багтаан танилцуулах

-Шүүгчдийн асуултад хариулах

<sup>1</sup>Идеатон гэдэг нь идея буюу санаа, марафон буюу уралдаан гэсэн хоёр үгний нийлмэл ба ур чадвар, нэгдмэл сонирхолтой хүмүүс нийлж тодорхой асуудлыг оношлох, хамгийн сайн боломжийг тодорхойлох, ашигтай шийдлийг санал болгож, санаачилга, шийдлийг хэрэгжүүлэх арга замыг агуулсан төлөвлөгөө юм.

**Шалгуур үзүүлэлт:** Урьдчилан ирүүлсэн видео, шалгаруулалтын үеийн Powerpoint танилцуулгын нэгдсэн үнэлгээгээр насны ангилал тус бүрээс шилдэг 2 баг (идеатон)-г шалгаруулна.

**Үнэлгээ:**

- Асуудал тодорхойлсон байдал
- Шийдэл санал болгосон байдал
- Хэрэглэх ашиглах боломж
- Өрсөлдөх давуу тал

**Шалгаруулалт:**

Насны ангилал тус бүрээс шилдэг хоёр багийг (идеатон) шалгаруулж санхүүжилтийг төслийн багт олгоно.

**Жич:**

- 1 дүгээр байр 1,5 сая төгрөг хүртэлх
- 2 дугаар байр 1,0 сая төгрөг хүртэлх

Шилдэг багууд шалгарсан төслийн санааг хэрэгжүүлэхэд аймгийн Засаг даргын Тамгын газар хамтран ажиллана.

Холбоо барих утас: 7032-3990, 8828-8355

**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**